

Түүх 2 : Закхай

Библийн эшлэл
[Лук19:10]

Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ гэв.

Иерихо хотод нэгэн жижигхэн биетэй Закхай гэдэг нэртэй татвар хураагч амьдарч байв.

Татвар хураагч гэдэг нь хүмүүсээс татвар хурааж авдаг хүнийг хэлнэ.

Закхай ядуу хүнээс хүртэл хүчээр татвар хурааж авдаг байлаа. Тиймээс хүмүүс Закхайг гэмтэн гэж хочилж түүнд дургүй байв.

Закхай хүмүүсээс хураасан татвараар баяжив. Хүмүүс Закхайг бүр илүүгээр үзэн ядаж дургүйлхэв.

Тиймээс Закхай үргэлж ганцаараа байдаг байлаа. Тэгтэл нэгэн өдөр Есүс Иерихо хотод ирэв.

Закхай Есүс гэж ямар хүн байдаг бол гэж бодож эхлэв. Есүс олон хот тосгодоор явж өвчтэй хүнийг эдгээж Бурханы тухай зааж сургадаг тухай сонссон учраас сонирхож байлаа. Закхай огт тээнэгэлзэлгүйгээр Есүстэй уулзахаар яарав.

Гэтэл аль хэдийн маш олон хүн байсан учир Есүсийн хажууд ойртож очихын арга байхгүй байв.

Жижиг биетэй Закхай инжир модны дээш авирч гарав.

Закхай Есүсийг харж байх үед, Есүс явж байснаа зогсон инжир модны зүг ширтэн харж Закхайд ингэж хэлэв.

Закхай хурдан буугаад ир, Би өнөөдөр танайд зочлон болно. Есүс Закхайг өмнө нь таньдаг байсан хүн шиг ярив.

Закхай маш баяртайгаар хурдан бууж ирэн гэртээ дагуулан ирэв.

Гэтэл олон хүмүүс энэ зүйлийг хараад хоорондоо шивэр авир хийцгээв. Харин Есүс үүнд анхаарлаа хандуулсангүй.

Закхай бүх зүйлээрээ Есүсийг дайлав. Тэгээд тэр Есүст ингэж хэлэв. “Есүс ээ, би өөртөө байгаа хөрөнгөний тэн хагасыг нь ядууст хувааж өгье. Тэгээд хүмүүсээс мэхэлж авсанаа дөрөв дахин нугалж эргүүлэн төлөх болно.”

Есүс түүнд ингэж хариулав. Закхай! Чиний бүхий л гэр бүл чинь аврагдах болно. Би энэ газарт ирсэн нь чамтай адил алдагдсан нэгнийг аврахын тулд юм.

Есүстэй уулзсан Закхай өөр хүн болон өөрчлөгджээ.

- Дараах библийн эшлэлийг дагаж бицээд, цээжлээрэй. (Лук19:10)

Алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ.






Бүтээлч байцгаая 2.

Закхайг Есүстэй уулзахад нь туслаарай.

1. Чидун модыг өнгөөр ялган будаж, доорх нүхийг гаргаарай.

2. Закхайг хайчилж аваад модон саван дээр наагаарай.

3. Гаргасан нүхэнд модон савааг хийж Закхайг модон дээрээс гулсан бүүж байгаагаар бүтээгээрэй.



Хэрэглэгдэх зүйлс:
Хайч, цавуу, өнгийн
харандаа, зайрмагны
мод

Жишээ зураг



